

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022.12.10

Дугаар 01

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 105, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын төв ордонд 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 11 цагт хосолсон хэлбэрээр танхимаар 183, зайнаас 176 нийт 359 хувьцаа эзэмшигчид оролцож 95.34 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хурлын дарга: Санжаагийн Мөнгөнчимэг – Сангийн дэд Сайд

Хуралд оролцсон: Б.Тэлмүүн- ТУЗ-ийн дарга
Б.Сүх-Очир - ТУЗ-ийн гишүүн
Г.Золбоо – ТУЗ-ийн гишүүн
Л.Сонор - ТУЗ-ийн гишүүн
М.Батжаргал -ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Энхжаргал - ТУЗ-ийн хараат бус гишүүн
С.Цэнд-Аюуш - ТУЗ-ийн хараат бус гишүүн
С.Баатарсүрэн – ХДК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга: Ө.Гантөр – Гүйцэтгэх захирал
Комиссын орлогч дарга: Э.Хангай – ТУЗ-ийн хуульч
Комиссын гишүүд: Г.Баясгалан – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Х.Лхагвасүрэн – ББТГ-ын захирал
М.Гантуяа – СГ-ын захирал
Г.Энхтамир – МТГ-ын захирал
А.Ганзориг – УАГ-ын захирал
Г.Содонбаатар – МОНХГ-ын захирал
Н.Энх-Амгалан – ДАГ-ын МТАТХ-ийн захирал

Комиссын нарын бичгийн дарга: Э.Уянга – ТУЗ-ийн мэргэжилтэн

Хурлын тооллогын комисс

Комиссын дарга: А.Батмөнх – ДХШГ-ын захирал
Комиссын гишүүд: Ц.Дамдинсүрэн – ЭУГ-ын захирал
Ш.Алтанчимэг – КГ-ын захирал
Б.Цэндсүрэн – МТГ-ын ХХ-ийн захирал
Комиссын нарийн бичгийн дарга: Л.Булгаа – ХҮА-ны менежер

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
2. “Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах.

СОНССОН нь:

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: “Төрийн банк” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй нийт 755,096,250 ширхэг хувьцаанаас тус хуралд саналын эрх бүхий 719,933,722 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор нийт саналын эрхтэй хувьцааны 95.34 хувь болж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах ирц бүрдэж, хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Нээлтийн үг хэлж хурлыг эхлүүлэн, ээлжит бус хурлын дэгийг танилцуулав.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Энэ удаагийн хурлын онцлог бол Төрийн банк анх удаа IPO амжилттай гаргаад олон нийтийн хувьцаат компани болон өөрчлөгдөж байгаа, анхны ээлжит бус хурал юм. Хувьцаа эзэмшигч Та бүхэндээ Төрийн банкны товч танилцуулгыг Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөр танилцуулна.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны тухай товч танилцуулгыг хийв.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хөтөлбөрийн дагуу үндсэн 3 асуудалдаа оръё. “Төрийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай” танилцуулгыг хийнэ үү хэмээн Та бүхэндээ Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийг индэрт урьж байна.

1. *“Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай*

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ө.Гантөр захиралд баярлалаа. Хурлын хөтөлбөрийн дагуу асуулт хариултын хэсэгтээ оръё. Та бүхэн 2 минутад багтааж асуултаа асууна уу.

Асуулт, хариулт санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс 7 хүн асуулт асууж, хариултыг өгөв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Заалнаас нийт 7 асуулт асуусан. Холбогдох дарга нар асуултад хариуллаа. Цахимаар асуулт ирээгүй байна. Дараагийн асуудал руугаа оръё. Төрийн банк ХК-ийн Дүрмийн төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Тэлмүүн танилцуулна.

2. “Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах тухай

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: “Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах тухай танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Компанийн дүрмийн төслийг танилцуулсан Б.Тэлмүүн даргад баярлалаа. Дүрмийн төсөлтэй холбогдолтой асуулт хариултын хэсэг рүү орёе. Асуулт асуух хувьцаа эзэмшигчид асуултаа асууна уу.

Асуулт, хариулт санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс 6 хүн асуулт асууж, хариултыг өгөв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Заалнаас 6 хүн асуулт асууж, удирдлагууд асуултад хариуллаа. Цахимаар асуулт болон санал ирээгүй. 2 дахь асуудлаа хэлэлцэж дууслаа. Одоо хөтөлбөрийн дагуу 3 дахь асуудал руугаа орёе. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцуулна.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг танилцуулав.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Энэ асуудалтай холбоотой асуулт хариулт руугаа орёе.

Асуулт, хариулт санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс 3 хүн асуулт тавьж, хариултыг өгөв.

Алтантүлхүүр, Хувьцаа эзэмшигч: Хяналтын зөвлөлийн хүний нөөц бүрдүүлэлтийг чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх санал гаргаж байна. Чадварлаг хүмүүс нь нэгдүгээрт, мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, туршлагатай чадварлаг, хоёрдугаарт, өндөр ёс зүйтэй байх ёстой. Тийм учраас хяналтын зөвлөлийн тоо 5 гэдэг нь бага харагдаж байна. 7000 хувьцаа эзэмшигчийг төлөөлж байгаа тул 1 хувь буюу 7 хүн, хяналтын зөвлөлийг ТУЗ-өөс нэр дэвшүүлсний дагуу бүрдүүлнэ гэдэг ойлгомжгүй санагдаж байна. Иймд хяналтын зөвлөлийг хувьцаа эзэмшигчдээс өөрсдөөс нь нэр дэвшүүлэх нь илүү зөв болов уу гэж бодож байна. Хоёрдугаарт ёс зүйн зөвлөл, хороо гэж бүдэг бадаг зүйл сонсогдлоо. Энэ нь хүний нөөцтэйгөө холилдсон сонсогдож байна. Ёс зүйн хороо нь дангаараа байж, мөн ёс зүйн хороонд аудиторуд, хуульчид, өмгөөлөгчид байх хэрэгтэй байна. Хяналтын зөвлөл дээр маш онцгой хүний нөөц хийж, хариуцлагатай бөгөөд мэргэжлийн өндөр түвшний хүмүүсийг оруулах нь зайлшгүй чухал байна. Хяналтын зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдээс сонгох саналтай байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Алтантүлхүүр хувьцаа эзэмшигчийн зүгээс тавьсан саналын дагуу Хяналтын зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна гэснийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэй болгох нь боломжтой гэж үзэж байна. Үүнийг Та бүхэн дэмжиж байвал гар өргөөд саналаа өгөөд явъя. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцээд өөрчлөөд явах бүрэн боломжтой. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 болгох дээр саналаа хураая.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Зааланд байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь гар өргөж дэмжиж байгаа тул хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй болгож байна. /Алх цохиж батлав./

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ёс зүйн хороотой холбоотой асуудал дээр Ө.Гантөр захирал хариулт өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Алтантүлхүүр хувьцаа эзэмшигчийн зүгээс маш зөв асуултуудыг тавьж байна. Төрийн банк нь 500 гаруй салбартай, 4000 гаруй ажилтантай том айл байгаа. Банканд ажиллаж байгаа ажилтан бүр ёс зүйтэй байх шаардлагыг нэн тэргүүнд тавьдаг. Хүний нөөцийн хороогоор ажилтнуудтай холбоотой асуудлуудыг авч хэлэлцдэг. Таны гаргаж байгаа саналыг хүлээж авахад бэлэн байна. Ёс зүйн дүрмийг бол баталсан мөрдөж ажиллаж байгаа. Удахгүй шүгэл үлээх бодлогыг баталж үйл ажиллагаандаа мөрдөөд явна. Ёс зүйн хороо байгуулагдаад явах боломжтой гэж бодож байна. Баярлалаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулахтай холбоотой хувьцаа эзэмшигч Алтантүлхүүрийн зүгээс тавьсан саналын дагуу Хяналтын зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна гэснийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэй болгох, мөн гишүүдээр олон төрлийн мэргэжлийн хүмүүсийг оруулахад анхаарч ажиллах санал гаргасныг Нэр дэвшүүлэх хороо анхаарч ажиллах нь зүйтэй. Цахимаар ямар нэгэн асуулт, тодруулах санал ирээгүй байна. Ингээд 3 дахь асуудлаа амжилттай хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн хурлын хэлэлцэх 3 асуудал тус бүрээр санал аваад нэгтгээд албажуулах процесс явагдана. Одоо хөтөлбөрийн дагуу 15 минут завсарлана. Энэ хооронд хувьцаа эзэмшигчид цахимаар болон цаасаар саналаа өгнө үү. 15 минутын дараа санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна. Мөн хурлаас гарсан шийдвэрүүдийг албан ёсоор Та бүхэндээ танилцуулаад өнөөдрийн үйл ажиллагаа өндөрлөнө. Завсарлагын цаг эхэлж байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Завсарлагын цаг дууслаа. Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга А.Батмөнхийг индэрт урьж байна.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, Тооллогын комиссын тогтоолыг дараах байдлаар танилцуулав.

1. “Төрийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 95.45 % ирцтэйгээр, 99.988 % зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
717,489,834	99.988 %	1	0.000 %	86,442	0.012 %

2. “Төрийн банк ХК-ийн дүрэм батлах” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 95.45 % ирцтэйгээр, 99.996 % зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,663,353	99.996 %	20,184	0.003 %	6,907	0.001 %

3. “Төрийн банк ХК-ийн хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 95.45 %

ирцтэйгээр, 99.973 % зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,496,896	99.973 %	2,620	0.000 %	189,573	0.026 %

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр, 3 тогтоолын төслийг тус тус уншиж танилцуулан хурлыг хаав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 250 /хоёр зуун тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 755,096,250.0 /долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь/ ширхэг энгийн хувьцаатай буюу нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 188,774,062,500.0 /нэг зуун наян найман тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу/ төгрөгөөр тогтоов.

2. “Төрийн банк” ХК-ийн дүрмийг хавсралт ёсоор батлав;

2.1 “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, шинээр батлагдсан дүрмийг хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгов;

2.2 “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д үүрэг болгов.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор батлав.

3.1 “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /Г.Золбоо/-нд үүрэг болгов.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

ХЯНАСАН:
ТУЗ-ИЙН ХУУЛЬЧ:

Э.ХАНГАЙ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 11:00 цагт, Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 105, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын төв ордонд хосолсон /танхим, цахим/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох			
2	“Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах			
3	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг төслийг батлах			

2022 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас /www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан: _____